



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 23 өдөр

Дугаар А/140

Чингис хот

Газар ашиглалтын зориулалтад
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийн 49.3.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалт, "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ын 3 дугаар зүйлийн 3.4.4-д заасныг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн Мягмарбаатарын Дагвын ирүүлсэн хүсэлтийн дагуу тус иргэний эзэмшлийн Хэрлэн сумын 2 дугаар баг /Булаг/ Баатрууд гудамж байрлах 1016 м² бүхий гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрыг үйлчилгээний зориулалттай болгон зориулалтыг өөрчлөн 46 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.


2. Иргэн М.Дагвын эзэмшил газрын кадастрын зураглалыг хавсралтаар баталсугай.

3. Газар эзэмших эрхийн гэрчилгээг олгон гэрээ байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, Барилга, хот байгуулалтын газар /Д.Баярхүү/-т үүрэг болгосугай.

4. Газар эзэмших гэрээнд тусгагдсан зориулалт, нөхцөлийн дагуу газраа эзэмшин, гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж байхыг иргэн М.Давгад даалгасугай.

5. Энэхүү захирамжийг гаргасантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2020 оны А/381 дүгээр, 2020 оны а/346 дугаар захирамжуудыг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231010382